

## ХӨГЖИЖ БАЙГАА ОРНУУДЫН ХҮН АМЫН ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨНИЙ БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТИЙН АСУУДЛУУД

(Орчуулга, "Population Movements in the Third World", Routledge, London, 1994.)

Л.Хишигсүрэн, НҮБ-ийн ХАС –н Хүн Ам ба  
Хөгжлийн асуудал хариуцсан зөвлөх

*НҮБ-аас 1978 онд хөгжил буурай 122 орныг хамруулсан судалгаагаар 116 оронд хүн амын хөдөөнөөс хот руу чиглэсэн шилжих хөдөлгөөнийг багасгах, хүн амын сийрэг суурьшилтыг дэмжсэн бодлого боловсруулан хэрэгжүүлж байв. Хотод шилжин ирэгч хүн амын олонхи нь өөрсдийнхөө амьдрал ахуйг шилжих хөдөлгөөний үр дүнд сайжирна хэмээн үзэж байсан ч, засгийн газрууд нь хүн амын шилжих хөдөлгөөнөөс тухайн улсын цаашдын хөгжилд нөлөөлөх сөрөг үр дагавар, хотын төвлөрөлд илүү санаа зовж байсан юм. Шилжих хөдөлгөөний оновчтой бодлогууд нь эерэг үр нөлөөг нэмэгдүүлж, сөрөг үр дагаврыг бууруулах ёстой. Тэгэхээр энэхүү бодлого нь өөрөө тийм ч амар зорилт биш бөгөөд аль нь "эерэг" аль нь "сөрөг" гэдгийг шийдвэрлэхэд хэцүү нөхцөлд эдгээр эерэг, сөрөг үр дагаврууд нь шилжих хөдөлгөөний ижил хэлбэрүүдээс ч үүсэн бий болж болох юм. Шилжих хөдөлгөөний талаархи бодлогууд болон хүн амын шилжих хөдөлгөөний хэлбэрүүдийг авч энд үзэх болно. Ерөнхийдөө шилжих хөдөлгөөний бодлогууд нь 1960, 1970-аад оны эхээр нэлээд өргөн хүрээтэй, хориглосон хэлбэртэй хэрэгжиж байгаад өнөө үед нэлээд хүмүүнлэг, бодитой хэлбэр лүү шилжээд байна.*

### Шилжих хөдөлгөөний эсрэг бодлогын хэлбэр

Шилжих хөдөлгөөний сөрөг үр нөлөөнд ихээхэн анхаарал хандуулж байсан бодлогын хэлбэр нь эрх мэдэл бүхий засгийн газруудын хэрэгжүүлж байсан бодлогын сул тал байсан. Тэд шилжигчдийн амьдрал ахуй эсвэл шилжих хөдөлгөөнийг нэмэгдүүлж буй байдлыг дүгнэж үзэхээсээ илүү хот руу чиглэсэн хүн амын хөдөлгөөний үр дагаварт анхаарал хандуулж байлаа. Шилжих хөдөлгөөнд саад хийх бодлогыг хэрэгжүүлэхдээ хөгжлийн тулгамдсан олон асуудлын илрэх шинж байдалд анхаарч байснаас бус уг асуудлуудын мөн чанарыг авч үздэггүй байжээ. Сүүлийн жилүүдэд бодлого боловсруулагчид нь шилжигчдийн эсрэг биш харин тэдний төлөө ажиллахыг илүүд үзэх болсон боловч хөгжиж буй зарим орнуудын засгийн газрууд шилжигчдийн олонхийг хөдөө нутаг руу буцах шийдвэр гаргах хүртэл нь тэдний амьдралыг хүндрүүлж байна.

Шилжих хөдөлгөөний эсрэг чиглэсэн бодлогуудын олонхи нь хүмүүсийг орон нутгаа орхин явах хүчин зүйлийн талаар эрх мэдэл бүхий

байгууллагууд ойлголт муутай байгаатай холбоотой. Тухайлбал 1970-аад оны үед Индонези улсын Жакарта хотыг “хаалттай хот” болгон тунхаглажээ. Хотод шилжин ирэхийн тулд иргэд урьд нь амьдарч байсан уугуул нутгаасаа явах зөвшөөрөл авч хотод “богино хугацаагаар суух карт”-тай болох шаардлагатай байжээ. Үүний зэрэгцээ тэд Жакарта хотынхноос 2 дахин их хэмжээний төлбөрийг барьцаанд өгөх ёстой. Гэвч ядуу иргэдийн хувьд энэхүү төлбөрийг хэзээ ч төлж чадахааргүй байв. Энэхүү төлбөрийг төлсөн иргэд хотод орж ирснийхээ дараа 6 сарын дотор тодорхой ажил, орон сууцтай болж чадвал дээрх төлбөрөө буцаан авч Жакарта хотын иргэн болсон үнэмлэх авдаг байжээ. Дээрх шаардлагыг хангаагүй шилжин ирэгчдийг хотоос албан хүчээр гаргадаг байв.

Дээрх үйл ажиллагааны зэрэгцээ Жакарта хотын эрх баригчид хууль бусаар ирсэн шилжигчид голдуу эрхэлдэг гудамжны цэвэрлэгч, гудамжны худалдаачдыг хүчээр хөөдөг байв. Жакарта хотын эрх баригчид болон Индонези улсын зарим хот, суурин газрууд хотод шилжих хөдөлгөөнийг картын системээр хориглож байсан боловч 1980 оноос эхлэн Индонези улсын Засгийн газраас шилжих хөдөлгөөн цаашид удаан хугацаанд зайлшгүй нэмэгдэнэ гэдгийг хүлээн зөвшөөрч, шилжилтийн улмаас үүсэх хотын хүн амын өсөлтийг дэмжсэн илүү хүнлэг бодлогыг саяхан боловсруулсан байжээ.

Шилжих хөдөлгөөнд хяналт тавьсан бодлогуудыг ямар нэгэн хэмжээгээр шүүмжилж байсан хэдий ч эдгээр нь хүмүүнлэг шинжид тулгуурлахаасаа илүү системчилсэн байдлыг илүүд үзэж байсан. Хөдөөнөөс хот руу шилжин ирэх хөдөлгөөнийг хянахад чиглэгдсэн бодлогуудыг хэрэгжүүлэх нь үнэхээр төвөгтэй байжээ. Хот руу орох гол гол замуудад шалгалт хийж, паспортын хуулийг хэрэгжүүлэх үйл ажиллагаа нь маш хүнд байв. Дээр өгүүлсэн Индонези улсын жишээнд шилжих хөдөлгөөний эсрэг бодлогууд шилжилтийг татаж байгаа хүчин зүйлийг барьж тогтооход үнэхээр хангалтгүй байлаа. Хүмүүс томоохон хотуудын ирээдүйн сайн сайхан амьдралын төлөв байдлыг эрэлхийлж, энэхүү боломжийг ашиглан баривчлагдах, шоронд хоригдох зэрэг аль муу зүйлүүдийг туулан хот руу ирсээр байсан юм. Ямар ч саад хоригийг бодлогын энэ хүрээнд тавьж байсан ч саяхныг хүртэл бодлого боловсруулагчид шилжих хөдөлгөөний үндсэн шалтгаануудтай тэмцэж хот руу чиглэсэн шилжих хөдөлгөөнийг хөнгөвчилж чадаагүй юм.

## **Шилжих хөдөлгөөний байршуулах бодлогын хэлбэр**

Бодлогын нэг хэлбэр нь шилжих хөдөлгөөн зайлшгүй гэдгийг хүлээн зөвшөөрч байсан ч шилжих хөдөлгөөний асуудалд өөр арга замаар ханддаг. Байршуулах бодлого нь үндсэндээ хүн амын шилжих хөдөлгөөний сөрөг үр дагаврыг тэдний уугуул нутаг болон шилжин очсон нутагт багасгахыг эрхэмлэдэг. Энэхүү бодлогын хүрээнд шилжигчдийг хотын үйлдвэржилтэд гол хувь нэмэр оруулах, хотоос хөдөө рүү орлогыг дахин хуваарилахад зонхилох үүрэг гүйцэтгэх, хот хөдөөг холбон хөгжүүлэхэд чухал хувь нэмэр үзүүлэх болно гэж үзээд шилжин ирэгчдийг эерэг талаас нь авч үзэхэд анхаарлаа хандуулдаг.

Хотуудын хувьд энэхүү бодлого нь хотод шилжин ирэгчдийн аж амьдралыг сайжруулах, тухайлбал, хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ, ажлын нөхцөлийг зохицуулсан хууль боловсруулах, ажиллах хүчний

шингээлт ихтэй үйлдвэрүүдийг дэмжих замаар ажлын байр бий болгох зэрэг арга хэмжээ авахад чиглүүлдэг. Малайз улсын засгийн газраас Куала Лумпур болон бусад хотуудад гудамжны жижиг худалдаачдыг тоног төхөөрөмж, зах зээлээр хангаж, сургалтанд хамруулах зэргээр тусалж, тэднийг ядуурлын гинжин хэлхээнд түлхэн оруулахад нөлөөлөх хүчин зүйлсийг арилгах арга хэмжээг авч байдаг. Хөгжиж буй хэд хэдэн орнуудад зөвшөөрөлгүй оршин суугчид болон ядуусын хорооллыг хуульчилж өгсөн явдал тэднийг хөөгдөх аюулаас чөлөөлж аюулгүй байдлыг хангаж өгч байгаа юм. Хэдийгээр эдгээр бодлогууд нь “шилжигчдэд” бус “хотын ядууст” үндсэндээ чиглэгдэж байгаа боловч өчүүхэн орлогоор голоо зогоож буй шилжин ирэгчдийн зонхилох хэсэгт тодорхой хувь нэмэр үзүүлнэ гэдэг нь бага зэрэг эргэлзээ төрүүлж байна.

Хөдөө газарт энэ бодлого нь цаашид шилжих хүсэлтэй хүмүүсийн боловсрол, сургалтад анхаарлаа хандуулдаг. Хүмүүсийг зах зээлээ хөтлөх тодорхой ур чадвартай болгож байгаа нь тэднийг уугуул нутгаа орхин явахаас сэргийлж байгаа нөгөө талаас тэднийг хот суурин газарт бага цалинтай ажил эрхлэх аргагүй байдалд орохоос сэргийлж байгаа юм.

Байршуулах бодлого нь шилжих хөдөлгөөнтэй холбоотой асуудлыг урт хугацаанд шийдвэрлэж чадахгүй бөгөөд учир нь шилжих хөдөлгөөнд нөлөөлж байгаа шалтгаануудыг биш харин шилжилтээс бий болж байгаа нөхцөл байдлуудад илүү анхаарал хандуулдаг. Гэхдээ өмнө дурдсан бодлогоос илүү хүмүүнлэг бөгөөд хүмүүсийн нүүн шилжих эрх, эрх чөлөөг дээдэлж, тэднийг амьдралын хэцүү нөхцөлд орохоос сэргийлж байдаг. Хотод хүмүүс шилжин ирсээр байх үед хотын удирдлага дээрх аргаар шилжигчдийн асуудлыг шийдвэрлэх явдал улам бүр хэцүү болж улмаар урт хугацаанд энэ асуудлыг хот шийдвэрлэж чадахгүйд хүрэх аюултай учраас энэ бодлого нь мөн л шүүмжлэлтэй байна.

### **Шилжих хөдөлгөөний удирдан чиглүүлэх бодлогын хэлбэр**

Энэ бодлого нь шилжих хөдөлгөөн зайлшгүй бөгөөд шилжилтийн бүх асуудлууд тааламжгүй биш юм гэдгийг хүлээн зөвшөөрч сөрөг үр дагаврыг багасгахыг оролддог. Энэхүү бодлогын үйл ажиллагаа нь хүн амын шилжих хөдөлгөөний хэв шинжийг өөрчилж, шилжилтийн эерэг үр нөлөөг нэмэгдүүлэхэд чиглэгдэж байдаг. Өөрөөр хэлбэл, ажил хөдөлмөр эрхлэх болон эдийн засгийн бусад боломжийг даган шилжиж байгаа хүмүүсийг аль хэрэгцээтэй газарт нь чиглүүлэн шилжих хөдөлгөөний урсгалыг өөрчилж байдаг. Хөгжиж байгаа орнуудад зонхилж буй хөдөөнөөс хот руу чиглэсэн шилжилт нь тийм ч аятай зүйл биш юм. Учир нь “хотжилтын ачаалал” үүсч, хөдөө орон нутгаас хүн хүчний нөөц шилэгдэн ирдэг. Иймээс энэхүү бодлого хүмүүсийн урсгалыг өөр газар нутаг руу чиглүүлэн өөрчлөх, ялангуяа ирээдүйд том хот болох хандлагатай дунд, багахан хэмжээний хот руу чиглүүлэхэд гол анхаарлаа хандуулдаг. Ингэж орон нутгийн хүрээнд тодорхой зайд шилжих хөдөлгөөнийг дэмжих нь жижигхэн тосгон, бүсийн төвүүдийг хөгжүүлэх, эдгээрийн хоорондын харилцан холбоог бэхжүүлэхэд тус болоод зогсохгүй томоохон хотуудын ачааллыг хөнгөвчилж өгдөгөөрөө ач холбогдолтой юм.

Тэгэхээр удирдан чиглүүлэх бодлогын энэ арга хэлбэр нь хүмүүсийн нүүн шилжих эрхийг дэмжиж, засгийн газар нь тэдний хаашаа

нүүх сонголтод нөлөөлж байдаг. Хүмүүсийн хувийн харилцаа холбоо болон эдийн засгийн боломжийг авч үзэх үзэл нь тэдний шилжин суурьших газраа сонгоход чухал үүрэг гүйцэтгэдэг. Тэгэхээр энэ бодлого хотын газар нутагт боломжуудыг бий болгоод зогсохгүй ирээдүйд шилжих хүсэл бүхий хүмүүст шилжигчдийн аж байдлын тухай мэдээллийг өгөхөд үйл ажиллагаагаа чиглүүлдэг. 1970, 1980-аад оны эхээр удирдан чиглүүлэх бодлогын гол чиглэл хотын үйлдвэржилтийн төвлөрлийг багасгаж, бүсийн төвийн өсөлтийг хангахад оршиж байв. Тайланд улсын засгийн газраас Бангконг хот руу шилжих хүн амын томоохон урсгалыг багасгахын тулд бүсийн төвүүдэд фирм, улсын үйлдвэрийн салбарыг дахин байршуулахыг урамшуулж, нийслэл хот руу шилжин ирэхээс урьдчилан сэргийлэхэд чиглүүлэн эдийн засгийн боломжуудыг орон нутагт бий болгосон байна. Харамсалтай нь засгийн газрын санхүүгийн энэ өгөөмөр урамшууллыг Бангконг хотын зөвхөн ойролцоох нутгуудад суурьшсан цөөхөн тооны фирмүүд хүртсэн юм. Иймд бүсийн төвүүд рүү хүн амын урсгалыг өөрчлөн чиглүүлэх боломж бага бүрдсэн байна. Үнэхээр Бангконг хотод шилжин ирэгч хүн амын тоо нэмэгдсэн бөгөөд ялангуяа засгийн газраас төвлөрлийг сааруулах зорилгоор хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүнд тухайлбал хөдөө орон нутгийн боловсрол, сургалт, харилцаа холбооны хөгжилд хийсэн хөрөнгө оруулалтын ачаар өндөр боловсрол мэдлэг эзэмшсэн хүмүүс нийслэл Бангконг хот руу шилжин иржээ. Шилжигчдийг бага, дунд хэмжээний хотууд руу чиглүүлсэн үйл ажиллагаанд учирч байсан бэрхшээлийг олонхи засгийн газрууд хүлээн зөвшөөрөөд байна. Үүний оронд шилжигчдийг томоохон хотуудын ойролцоо орших дагуул хотууд руу чиглүүлэх ёстой байв. Бодлогын арга хэмжээ нь Мексик, Өмнөд Солонгост амжилттай хэрэгжиж нийслэл Сөүл хот руу олон тооны хүмүүс шилжин ирэхийг болиулж чадсан юм. Хөгжиж буй орнуудын томоохон хотуудын төвүүдийн ойролцоо шилжих хөдөлгөөнийг чиглүүлэхэд энэ бодлого нь маш үр ашигтай хэрэгжиж байсан боловч харамсалтай нь шилжих хөдөлгөөний гол төвлөрөл эдийн засгийн хувьд илүү хөгжилтэй бүсүүдэд нэвтрэн орсон юм. Эдгээр бодлогууд зарим талаараа тухайлбал, эдийн засгийн үйл ажиллагааг тархаан өргөжүүлэх, шилжигчдийн шинж байдлыг өөрчлөхөд ач холбогдолтой юм. Удирдан чиглүүлэх бодлогыг боловсруулахдаа нь өөрөө бус харин хүн амын шилжих хөдөлгөөний хэв шинжид нөлөөлөх хязгаарлагдмал үр дүнгүүдийг хангалтгүй тооцоолж хэрэгжүүлсэнд гол дутагдал оршиж байна.

### **Шилжих хөдөлгөөнөөс урьдчилан сэргийлэх бодлогын хэлбэр**

Дээр дурьдсан бодлогууд шилжих хөдөлгөөний суурь шалтгаануудыг ялангуяа хөдөө нутаг дахь шилжигчдийн асуудлыг анхааралдаа төдийлөн аваагүй юм. Иймд хөдөөнөөс хот руу чиглэсэн шилжих хөдөлгөөнтэй холбогдон үүсч буй асуудлыг урт хугацаанд тогтвортой шийдвэрлэх нь зүйтэй. Урьдчилан сэргийлэх бодлого нь шилжилтийн улмаас үүсэх шинж байдлуудад санаа зовохоосоо илүү шилжих хөдөлгөөнд нөлөөлж буй шалтгаанууд ялангуяа ядуурал, тэгш бус байдал, ажилгүйдлийн эх үүсвэртэй тэмцэх, түүнчлэн ирээдүйн шилжигчдийн хот руу татагдах сонирхлыг хянахад чиглэсэн арга хэмжээг зохицуулдаг. Хэдийгээр энэ бодлогын үр дүнгүүд нь аажим, тийм ч ил тодорхой бус байдгаараа шилжих хөдөлгөөний түвшин болоод хэв шинжид нөлөөлөхдөө илүү үр ашигтай байж чадна гэдэгт бага зэрэг

эргэлзээ үүсдэг. Энэхүү тааламжтай бус шинж, хангалтгүй хэрэгжилт нь хүн амын шилжих хөдөлгөөний түвшинд нөлөөлөх ач холбогдол, үр дүнг нь хязгаарлаж байдаг.

Хөдөө нутгаас хүмүүс шилжин явах шийдвэр гаргахад нөлөөлөх гол хүчин зүйлүүдийн дотор газар, ажлын байр, орлого чухал байр суурийг эзэлдэг. Хөдөөд газрын тэгш бус хуваарилалт, далд ажилгүйдэл, ядуурлын асуудлыг тодорхой хэмжээгээр шийдвэрлэх явдал хүмүүсийн шилжин явах хэрэгцээг бууруулахад нөлөөлдөг. Хөгжиж буй олон орнуудад газрын шинэчлэлийн хөтөлбөр хэрэгжүүлж, газаргүй буюу маш бага газартай хүмүүст газар дахин хуваарилсан нь тэднийг газрын үйлдвэрлэлээр амьжиргаагаа хангах боломжийг бий болгосон юм. Томоохон газар эзэмшигчдийн мөлжлөг болон газар ашиглагчдын зохисгүй үйл ажиллагааг багасгах замаар хөдөө нутгаас хүмүүс шилжин явах шалтгааныг бууруулж байсан боловч энэ талаар хэрэгжүүлсэн ахиц тийм ч сайн байгаагүй. Учир нь хөгжиж буй цөөхөн орнууд “газар” шинэчлэлийн хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлэх улс төрийн хүсэл сонирхол, чадвартай байв.

1960-аад оны сүүлч, 1970-аад оны эхээр Перу улсын далайн эрэг орчмын бүс нутгуудад саахарын тариалангийн талбайн оронд хөдөө аж ахуйн хоршооллуудыг дэмжин хөгжүүлсэн үйлдвэрлэл, бүтээмжийг нэмэгдүүлэхэд маш үр ашигтай байсан боловч бүтээмж өсөхийн хэрээр газраас чөлөөлөгдсөн илүүдэл ажиллах хүчин бий болж гадагш шилжих хөдөлгөөн нэмэгджээ. Үүнтэй нэгэн адил нөхцөл байдал Латин Америкийн улсуудад бий болсон юм. Газрын шинэчлэлийг хэрэгжүүлэх замаар феодалын фермерийн системийг устгасан нь үр ашгийг нэмэгдүүлсэн боловч мөн л хөдөөгийн асар олон оршин суугчдыг өөр газар нутагт ажил хайж нүүхэд хүргэжээ. Хөдөө аж ахуйг эрчимжүүлэх талаар хэрэгжүүлж байсан хөтөлбөр нь олон хүмүүст газар тариалан эрхлэхтэй холбоотой ажил мэргэжил эзэмших нөхцөлийг бүрдүүлэхэд тодорхой ач холбогдолтой байсан боловч хөдөөнөөс шилжин ирэгчдийн тоо хэмжээг бууруулахад мөн л үр ашиг өгсөнгүй. Ихэнх тохиолдолд эдгээр хөтөлбөрүүд нь ажил эрхлэх боломж олгохоосоо илүү хүнсний аюулгүй байдлыг хангаж байв. Малайз улсын баруун хойд хэсэгт хэрэгжсэн Муда хэмээх систем цагаан будаа тариалдаг гол гол бүсүүдийн усжилтын системд хөрөнгө оруулалт хийж цагаан будааны үйлдвэрлэлийг нэмэгдүүлэхэд гол анхаарлаа хандуулж байсан. Энэхүү систем нь жилийн цагаан будааны үйлдвэрлэлийг 2 дахин өсгөж, бүтээмж, ажлын байрыг нэмэгдүүлж газаргүй хүмүүсийг ажлаар хангахад маш амжилттай нөлөөлсөн юм.

## **Дүгнэлт**

Дээр дурдсан бодлогын хэлбэрүүд нь хот руу шилжих хөдөлгөөнийг сааруулах, шилжих хөдөлгөөний сөрөг үр дагаврыг багасгах, эерэг үр нөлөөг дээшлүүлэхэд тэр бүр үр ашгаа тэр бүр өгсөнгүй. Учир нь бодлого төлөвлөлтийн хэд хэдэн сул талуудыг энд дурдаж болно.

*Нэгдүгээрт:* бодлого боловсруулагчид нь шилжих хөдөлгөөний талаар шийдвэр гаргахад нөлөөлж байгаа цогц хүчин зүйлсийн тухай сайн мэдлэг байсангүй.

*Хоёрдугаарт:* бодлогууд нь ихэнхдээ “ганцхан хүчин зүйл”-ийг шийдвэрлэх тухайлбал, хотын орон сууцны байдлыг сайжруулах, хөдөөд ажлын байр нэмэгдүүлэх зэрэгт гол анхаарлаа чиглүүлж байв.

*Гуравдугаарт:* шилжих хөдөлгөөнд нөлөөлөх асуудлыг бодлогын шууд зорилт болгон тавьж байгаагүй бөгөөд харин хөдөө, бүс нутгуудын хөгжлийн талаар хэрэгжүүлэх томоохон бодлогын үр дүнд бий болно гэж найдаж байсан.

*Дөрөвдүгээрт:* шилжих хөдөлгөөний талаар тусгайлан хэрэгжүүлж байсан бодлогууд нь ихэнхдээ хот болон аж үйлдвэрийн хөгжилд гол анхаарлаа төвлөрүүлэн эдийн засгийн өсөлтийг дэмжих томоохон хөтөлбөрүүдийн нөхцөл байдал дунд хэрэгжиж байсан бөгөөд энэ нь эргээд хөгжлийн ялгааг нэмэгдүүлэхэд нөлөөлж байсан.

Шилжих хөдөлгөөний хэмжээ, шинж байдалд амжилттай нөлөөлсөн орнууд тухайлбал, Венесуэл, Өмнөд Солонгос, Малайз улсууд нь хөгжлийн талаарх төрөл бүрийн хөтөлбөрөө зүй зохистой хэрэгжүүлэх санхүүгийн нөөцтэй байсны зэрэгцээ шилжих хөдөлгөөний бодлогыг үр ашигтай хэрэгжүүлэх эрх мэдэл, улс төрийн ихээхэн үүрэгтэй байсан юм. Хөгжиж буй орнуудын ихэнх нь хангалттай нөөц, бүрэн эрх мэдэлгүй нөхцөлд байгаа ч гэсэн шилжих хөдөлгөөний үйл явц, хэв шинжид цаашид нөлөөлөх нь зайлшгүй учраас зөв гэж таамаглаж буй бодлогын зайлшгүй, тусгайлсан арга хэмжээнүүдийг авах гарцаагүй шаардлагатай юм. Хөгжиж буй орнуудын хүн амд шилжих хөдөлгөөний үр дүнд эдийн засгийн болон бусад боломжуудыг үргэлжлүүлэн эзэмших найдвар тавих нь чухал юм. Гэхдээ энэ үйл явцын дунд тэдний уугуул нутгийн нөхцөл байдал дээшлэх талаар өөрсдийнх бүрэн итгэл урт хугацаанд буурч болно. Шилжих хөдөлгөөний үр дүнд хэн хохирч, хэн хожиж, хэн нүүж чадах вэ гэдгийг засгийн газар бус харин зах зээлийн хүчин зүйлүүд тодорхойлсоор байх болно.

## **Гол үзэл санаа**

1. Хүн амын шилжих хөдөлгөөнд хууль зүйн болоод захиргааны саад хориг тавих бодлогыг шилжих хөдөлгөөний суурь шалтгаан болгон авч үзэх нь ирээдүйг харах ур чадвар болоод хохирлыг мэдрэх дутмаг байдлыг илэрхийлж буй бөгөөд хөдөөнөөс хот руу шилжин ирэгчдийн асуудлыг урт хугацаанд шийдвэрлэж чаддаггүй.
2. Шилжих хөдөлгөөний хамгийн оновчтой бодлого нь шилжилтийн улмаас үүсэх сөрөг үр дагаврыг багасгахын зэрэгцээ эерэг үр дүнг нэмэгдүүлэхэд чиглэсэн байх ёстой.
3. Шилжигчдийн оршин сууж байсан уугуул нутгийн нөхцөл байдлыг сайжруулах замаар хөдөөнөөс хот руу чиглэсэн хөдөлгөөнийг хянасан нь эдийн засгийн үр ашгийг нэмэгдүүлж, тэдний ур чадвар, хэрэгцээ дээшлэн, газраасаа салахад нэлээн эерэг үр дүн үзүүлсэн байна.
4. Хөгжиж буй ихэнх орнуудын эрх бүхий байгууллагуудаас хот суурин газарт шилжин ирэгчдэд тулгарч байсан төвөгтэй нөхцөл байдлыг хөнгөвчлөх талаар явуулж байсан үйл ажиллагаа нь цаашид хүн ам хөдөөнөөс хот руу шилжин ирэх сонирхлыг нэмэгдүүлсэн байна.

5. Шилжих хөдөлгөөний тоо хэмжээ, хэв шинжид амжилттай нөлөөлж чадсан засгийн газрууд нь нэг талаас санхүүгийн зохистой нөөцтэй байсан, нөгөө талаар шилжих хөдөлгөөний бодлогуудыг үр ашигтай хэрэгжүүлэх бүрэн эрх мэдэл, улс төрийн хүсэл эрмэлзэлтэй байв. Түүнчлэн тэд эдийн засгийн хөгжил, нийгмийн өөрчлөлтийн талаар хэрэгжүүлж буй томоохон хөтөлбөрүүдэд шилжих хөдөлгөөний бодлогыг уялдуулж чадсан юм.